**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 26 дугаар цэцэрлэг 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДАА-2026/85/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дархан-Уул аймаг<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:<br>Утас: 70378845<br>Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: С.Батцэцэг<br>Утас: 70373089<br>Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn<br><br>Аудитор: Ч.Гантулга<br>Утас: 99372297<br>Цахим хаяг: tsesb.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ....................................................3
Асуудлыг онцолсон хэсэг....................................................3
Аудитын гол асуудал....................................................3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ....................................................5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА....................................................10
4. АУДИТЫН ТАЙЛАН....................................................13
4.1 Ерөнхий зүйл....................................................16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал......16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....................................................16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....................................................16
4.5.1 Завсрын аудитын талаар....................................................17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал....................................................17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....................................................17
5.1 Төлбөрийн акт....................................................18
5.2 Албан шаардлага....................................................18
5.3 Зөвлөмж....................................................18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....................................................20

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗГНХ,ЗДНХөрөнгө | Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 156

танай ________________-ны №__________________ -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 26 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
М.ОЮУНБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 26 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 26 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант хугацаанд Дархан сумын Орон нутгийн өмчийн газрын даргын А/03 тоот тушаалаар Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газраас 11,279.5 мянган төгрөгийн тавилга эд хогшил, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3,564.0 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжийг бүртгэж, санхүүгийн тайланд толилуулж тодруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 121,860.9 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 24 хувиар өссөн байна.

4526050109

**Бусад асуудал**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан сумын 26 дугаар цэцэрлэгийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 14 зорилтын хүрээнд 69 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 94 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр аймгийн Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **155,803,959.21** | **86,776,415.15** |
| 31 | **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө** | **112,085,132.21** | **33,111,995.86** |
| 312 | **Банкинд байгаа** | 112,085,132.21 | 33,111,995.86 |
| 3121 | **Төгрөг** | 112,085,132.21 | 33,111,995.86 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 112,085,132.21 | 33,111,995.86 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | **43,718,827.00** | **53,664,419.29** |
| 351 | Түүхий эд материал | **524,290.00** | **371,500.00** |
| 35130 | Эм боох материал | 524,290.00 | 371,500.00 |
| 354 | **Хангамжийн материал** | **43,194,537.00** | **53,292,919.29** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 689,500.00 | 1,326,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 29,554,662.00 | 23,048,932.00 |
| 35460 | Хүнсний материал | 7,145,375.00 | 6,698,644.16 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,805,000.00 | 22,219,343.13 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **901,844,121.70** | **898,596,707.90** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **901,844,121.70** | **898,596,707.90** |
| 392 | **Биет хөрөнгийн дүн** | **867,065,746.72** | **863,999,582.96** |
| 39201 | Барилга байгууламж | 900,000,000.00 | 900,000,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (93,750,000.00) | (108,750,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж | 70,460,168.00 | 82,611,008.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (24,882,595.49) | (29,428,242.90) |
| 39207 | Тавилга, эд хогшил | 24,182,736.06 | 21,301,394.56 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (13,350,536.91) | (12,981,980.80) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 18,615,900.66 | 28,615,900.66 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (14,454,425.60) | (17,368,496.56) |
| 39217 | Ном | 244,500.00 | - |
| 393 | **Биет бус хөрөнгийн дүн** | **34,778,374.98** | **34,597,124.94** |
| 39301 | Программ хангамж | 725,000.00 | 725,000.00 |
| 39302 | Хасагдуулга | (90,625.02) | (271,875.06) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 34,144,000.00 | 34,144,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,057,648,080.91** | **985,373,123.05** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,057,648,080.91** | **985,373,123.05** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,057,648,080.91 | 985,373,123.05 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал | 941,267,564.11 | 941,267,564.11 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | **107,436,516.80** | **35,161,558.94** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 107,436,516.80 | 107,436,516.80 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (72,274,957.86) |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 8,944,000.00 | 8,944,000.00 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН** | **1,057,648,080.91** | **985,373,123.05** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **778,859,200.00** | **789,773,200.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **36,416,000.00** | **34,404,600.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | **36,416,000.00** | **34,404,600.00** |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 12,523,000.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 23,893,000.00 | 26,299,080.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | - | 8,105,520.00 |
| 13 | **ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **742,443,200.00** | **755,368,600.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **697,146,200.00** | **719,823,400.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 697,146,200.00 | 719,823,400.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **45,297,000.00** | **35,545,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 45,297,000.00 | 35,545,200.00 |
| 2 | **Үйл ажиллагааны зардал** | **709,029,786.77** | **861,423,999.89** |
| 21 | **Урсгал зардал** | **709,029,786.77** | **861,423,999.89** |
| 210 | **Бараа, үйлчилгээний зардал** | **692,976,806.02** | **848,611,147.78** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал** | **498,706,103.20** | **620,567,000.00** |
| 210101 | Үндсэн цалин | 340,458,352.20 | 388,954,495.91 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 136,761,418.00 | 180,809,171.09 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 22,003,000.00 |
| 210104 | Урамшуулал | 21,486,333.00 | 28,800,333.00 |
| 2102 | **Нийгмийн даатгалын шимтгэл** | **60,567,618.34** | **73,312,536.35** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын | 41,185,976.47 | 49,856,572.72 |
| 210202 | тэтгэмжийн даатгалын | 4,845,385.47 | 5,865,590.91 |
| 210203 | ҮОМШӨ-ий даатгалын | 2,394,524.17 | 2,933,845.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын | 2,422,692.73 | 2,933,845.45 |
| 210205 | ЭМ-ийн даатгалын | 9,719,039.50 | 11,722,681.82 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **17,098,419.25** | **20,479,547.89** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 5,600,450.10 | 7,102,750.17 |
| 210302 | Түлш,халаалтын зардал | 6,613,852.08 | 6,081,058.72 |
| 210303 | Цэвэр бохир усны зардал | 4,884,117.07 | 7,295,739.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **7,010,488.00** | **1,588,750.00** |
| 210401 | Бичиг хэргийн зардал | 4,602,250.00 | 1,010,850.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн зардал | 196,400.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,211,838.00 | 577,900.00 |
| 2105 | **Нормативт зардал** | **62,318,937.40** | **68,739,130.84** |
| 210502 | Хоол, хүнс | 62,318,937.40 | 68,739,130.84 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **9,000,000.00** | **20,000,000.00** |
| 210604 | Урсгал засварын зардал | 9,000,000.00 | 20,000,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс** | **1,905,300.00** | **4,087,700.00** |
| 210802 | Аудит баталгаажуулалтын зардал | - | 684,000.00 |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 1,905,300.00 | 3,403,700.00 |
| 2109 | **Бараа, үйлчилгээний бусад зардал** | **36,369,939.83** | **39,836,482.70** |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,409,260.00 | 9,532,490.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 26,960,679.83 | 30,303,992.70 |
| **213** | **Урсгал шилжүүлэг** | **16,052,980.75** | **12,812,852.11** |
| | Бусад урсгал шилжүүлэг | 6,854,400.00 | 7,747,200.00 |
| | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 6,854,400.00 | 7,747,200.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **9,198,580.75** | **5,065,652.11** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,198,580.75 | 5,065,652.11 |
| **3** | **Үйл ажиллагааны үр дүн** | **69,829,413.23** | **(71,650,799.89)** |
| **225** | **Үйл ажиллагааны бус зардлын дүн** | **-** | **624,157.97** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **-** | **624,157.97** |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал-үндсэн хөрөнгө | - | 624,157.97 |
| **4** | **Үйл ажиллагааны бус үр дүн** | **-** | **(624,157.97)** |
| **5** | **Үйл ажиллагааны нийт үр дүн** | **69,829,413.23** | **(72,274,957.86)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **742,443,200.00** | **755,368,600.00** |
| 13 | **ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **742,443,200.00** | **755,368,600.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **697,146,200.00** | **719,823,400.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 697,146,200.00 | 719,823,400.00 |
| 1320 | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **45,297,000.00** | **35,545,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 45,297,000.00 | 35,545,200.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **697,518,104.54** | **829,170,236.35** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **697,518,104.54** | **829,170,236.35** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **681,465,123.79** | **816,357,384.24** |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал** | **498,706,103.20** | **620,567,000.00** |
| 210101 | Үндсэн цалин | 340,458,352.20 | 388,954,495.91 |
| 210102 | Нэмэгдэл | 136,761,418.00 | 180,809,171.09 |
| 210103 | Хоол унаа хөнгөлөлт | - | 22,003,000.00 |
| 210104 | Урамшуулал | 21,486,333.00 | 28,800,333.00 |
| 2102 | **Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **60,567,618.34** | **73,312,536.35** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын | 41,185,976.47 | 49,856,572.72 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын | 4,845,385.47 | 5,865,590.91 |
| 210203 | ҮОМШӨ-ий даатгалын | 2,394,524.17 | 2,933,845.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын | 2,422,692.73 | 2,933,845.45 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын | 9,719,039.50 | 11,722,681.82 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **17,098,419.25** | **20,479,547.89** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 5,600,450.10 | 7,102,750.17 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 6,613,852.08 | 6,081,058.72 |
| 210303 | Цэвэр бохир усны зардал | 4,884,117.07 | 7,295,739.00 |
| 2105 | **Нормативт зардал** | **63,855,083.00** | **68,292,400.00** |
| 210502 | Хоол, хүнс | 63,855,083.00 | 68,292,400.00 |
| 2106 | **Эд хогшил урсгал засвар** | **19,000,000.00** | **10,000,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 19,000,000.00 | 10,000,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,168,500.00** | **4,087,700.00** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 684,000.00 |
| 210806 | Мэдээлэл технологийн үйлчилгээ | 2,168,500.00 | 3,403,700.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **20,069,400.00** | **19,618,200.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,215,000.00 | 13,330,200.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,854,400.00 | 6,288,000.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **16,052,980.75** | **12,812,852.11** |
|  | Бусад урсгал шилжүүлэг | 6,854,400.00 | 7,747,200.00 |
|  | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 6,854,400.00 | 7,747,200.00 |
| 2134 | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **9,198,580.75** | **5,065,652.11** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,198,580.75 | 5,065,652.11 |
| 3 | **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **44,925,095.46** | **(73,801,636.35)** |
| 6 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **(3,690,900.00)** | **(5,171,500.00)** |
| 8 | **Нийт цэвэр мөнгөн гүйлгээ** | **41,234,195.46** | **(78,973,136.35)** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл |  | 112,085,132.21 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл |  | 33,111,995.86 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны үр дүн |
|---|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3 | 4 |
| **2024 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл** | **941,267,564.11** | **8,944,000.00** | **37,625,226.19** | **978,874,667.68** |
| НББ-ийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | - |
| ҮХ-ийн өсөлт, бууралт | | | | - |
| ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | 8,944,000.00 | | **8,944,000.00** |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| Тайлант үеийн үр дүн | | | 69,829,413.23 | **69,829,413.23** |
| **2024 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл** | **941,267,564.11** | **8,944,000.00** | **107,436,516.80** | **1,057,648,080.91** |
| НББ-ийн бодлогын өөрчлөлт | | | - | - |
| ҮХ-ийн өсөлт, бууралт | | - | | - |
| ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт | | | | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | - |
| Тайлант үеийн үр дүн | | | (72,274,957.86) | **(72,274,957.86)** |
| **2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл** | **941,267,564.11** | **8,944,000.00** | **35,161,558.94** | **985,373,123.05** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **1** | **ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО** | **755,368,600.00** | **749,302,947.89** | **(6,065,652.11)** | **99.2** |
| **131** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **719,823,400.00** | **718,823,400.00** | **(1,000,000.00)** | **99.9** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 719,823,400.00 | 718,823,400.00 | (1,000,000.00) | 99.9 |
| **132** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **35,545,200.00** | **30,479,547.89** | **(5,065,652.11)** | **85.8** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 35,545,200.00 | 30,479,547.89 | (5,065,652.11) | 85.8 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 113,085,132.21 | 1,000,000.00 | (112,085,132.21) | 0.88 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | 100 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 112,085,132.21 | - | (112,085,132.21) | - |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **868,453,732.21** | **750,302,947.89** | **(118,150,784.32)** | **86.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **861,997,500.00** | **829,276,084.24** | **(32,721,415.76)** | **96.2** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **854,250,300.00** | **821,528,884.24** | **(32,721,415.76)** | **96.2** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **634,964,300.00** | **620,567,000.00** | **(14,397,300.00)** | **97.7** |
| 210101 | Үндсэн цалин | 411,201,800.00 | 388,954,495.91 | (22,247,304.09) | 94.6 |
| 210102 | Нэмэгдэл | 186,111,900.00 | 180,809,171.09 | (5,302,728.91) | 97.2 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 22,003,000.00 | 22,003,000.00 | |
| 210104 | Урамшуулал | 37,650,600.00 | 28,800,333.00 | (8,850,267.00) | 76.5 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **78,273,000.00** | **73,312,536.35** | **(4,960,463.65)** | **93.7** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 53,113,500.00 | 49,856,572.72 | (3,256,927.28) | 93.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,289,800.00 | 5,865,590.91 | (424,209.09) | 93.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,145,000.00 | 2,933,845.45 | (211,154.55) | 93.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,145,000.00 | 2,933,845.45 | (211,154.55) | 93.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,579,700.00 | 11,722,681.82 | (857,018.18) | 93.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **32,560,800.00** | **20,479,547.89** | **(12,081,252.11)** | **62.9** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,135,000.00 | 7,102,750.17 | (3,032,249.83) | 70.1 |
| 210302 | Түлш, халаалт | 11,425,800.00 | 6,081,058.72 | (5,344,741.28) | 53.2 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,000,000.00 | 7,295,739.00 | (3,704,261.00) | 66.3 |
| **2105** | **Нормативт зардал** | **69,051,800.00** | **68,292,400.00** | **(759,400.00)** | **98.9** |
| 210502 | Хоол, хүнс | 69,051,800.00 | 68,292,400.00 | (759,400.00) | 98.9 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **10,000,000.00** | **10,000,000.00** | **-** | **100** |
| 210604 | Урсгал засвар | 10,000,000.00 | 10,000,000.00 | - | 100 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **3,403,700.00** | **3,403,700.00** | **-** | **100** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,403,700.00 | 3,403,700.00 | - | 100 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **25,996,700.00** | **25,473,700.00** | **(523,000.00)** | **98** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,708,700.00 | 19,185,700.00 | (523,000.00) | 97.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,288,000.00 | 6,288,000.00 | - | 100 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,747,200.00** | **7,747,200.00** | **-** | **100** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **7,747,200.00** | **7,747,200.00** | **-** | **100** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,747,200.00 | 7,747,200.00 | - | 100 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН** | **861,997,500.00** | **829,276,084.24** | **(32,721,415.76)** | **96.2** |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 112,085,132.21 | 112,085,132.21 | - |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 33,111,995.86 | 33,111,995.86 | - |
| 2 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | - | 100 |
| 3 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100 |
| 5 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 26 | 24 | (2.00) | 92.3 |
| 6 | Удирдах ажилтан | 2 | 2 | - | 100 |
| 7 | Гүйцэтгэх ажилтан | 10 | 10 | - | 100 |
| 8 | Үйлчлэх ажилтан | 14 | 12 | (2.00) | 85.7 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,789.8 мянган төгрөгийн алдаа[1] илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд:

- Тайланд онд санхүүгийн байдлын тайлан, орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангуудын уялдаа холбоог шалгахад 3,789.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Нягтлан бодох бүртгэлийн зарчим" 5.1.4. "үнэн зөв байх" заалт, УСНББОУС-1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", санхүүгийн тайлангийн аудитын "Ангилал", "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул үндсэн хөрөнгө дансанд бүртгэж, санхүүгийн тайлангуудын алдааг залруулав.

Мөн аудитаар нийт 5,326.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрсэн тул төсөвт буцаан төвлөрүүлэх 600.0 мянган төгрөгийн акт, 4,726.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт

**<u>5.1.1 Илрүүлэлт:</u>** Тус цэцэрлэгийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч М.Оюунбаярын сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан "*Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам*"-ын хавсралт "*Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар*"-ын 3-д "*Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана*" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

**<u>5.2.1.Илрүүлэлт:</u>** Тус цэцэрлэгийн эрхлэгч М.Оюунбаяр нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 1,608.0 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "*Төсвийн байгууллагын өдөр тутмын **үйл ажиллагааг удирдах***", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "*Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, **хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна***", 27.6-д "*Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална*", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт "*Төрийн болон*

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

*төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг **аль нэг ажилтанд хавсран хариуцуулна**. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно"* гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

***5.2.2.Илрүүлэлт:*** Тус цэцэрлэгийн нягтлан бодогч У.Бямбацогд Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн А/13 дугаар тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүлж, 3,118.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах*", 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"* Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4-д "*Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай"*, "Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.8-д "*Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 15 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сар бүр тооцож, улирал бүр олгоно"* гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

**5.3 Зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс: Залруулсан | | Үнээс: Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн хоорондын уялдаа 3,789,843.13 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. | 1 | 3,789.8 | - | - | - | - | 1 | 3,789.8 | - | - | - | - |
| **Дүн** | **1** | **3,789.8** | **-** | **-** | **-** | **-** | **1** | **3,789.8** | **-** | **-** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тус цэцэрлэгийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч М.Оюунбаярын сургалтын төлбөрт 600,000.00 төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна | 1 | 600.0 | 1 | 600.0 | - | - | - | - | - | - | - | - |
| Тус цэцэрлэгийн эрхлэгч М.Оюунбаяр нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 1,608,000.00 төгрөг авч, хууль тогтоомжийн | 1 | 1,608.0 | - | - | 1 | 1,608.0 | - | - | - | - | -- | - |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна. | | | | | | | | | | | | |
| Тус сургуулийн нягтлан бодогч У.Бябамцогтд Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичиг, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн Б/31 дүгээр тушаалыг тус тус үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүлэн 3,118,000.00 төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна. | 1 | 3,118.0 | - | - | 1 | 3,118.0 | - | - | - | - | - | - |
| **Дүн** | 3 | 5,326.0 | - | - | 2 | 4,726.0 | - | - | - | - | - | - |